

АЖЛЫН ХУУДАС 2 (унших чадвар)

Алхам 1. Дараах эхийг анхааралтай уншаарай.

Өндөр болоорой

Би аавтайгаа хамт автобусанд явж байлаа. Хүн цөөхөн тул бид хоёр хоёулаа сандал дээр сууж явав. Тэгтэл хүнд тортой зүйл барьсан нэг эмээ ороод ирлээ.

Би “Эмээ, та ийшээ сүү” гээд бушуухан босов. Эмээ толгойг минь илснээ “Ямар сайн охин бэ, өндөр болоорой” гээд чихэр өглөө. Харин аав “Бусдыг хүндэлдэг ухаантай охин шүү” гээд духан дээр минь үнсэв.

Өндөр настнаа хүндэлбэл өдөр болгон ийм гоё үг сонсох болов уу? Бас түүний хэлснээр өндөр болох болов уу?

Алхам 2. Эхийг уншаад дараах асуултын зөв хариуг сонгоорой.

Эмээ хүүд
яагаад чихэр
өгсөн бэ?

Охин гоё үг сонсохын
тулд л эмээд суудал
тавьж өгсөн үү?

Өндөр болоорой!
гэсэн үгийг чи юу гэж
ойлгож байна?

Алхам 3. Үгсийг уншаад ерөөлийн үгийг сонгоорой

Баярлалаа

Өндөр болоорой

Гялайлаа

Хичээгээрэй